



**ӨСВӨР ҮЕ ХҮНС ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1, 47.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 10 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”, “Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын захирлын 2023 оны А/03 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус байгууллагад 2023 онд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагаа, тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх гүйцэтгэгчдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, зааврын дагуу сонгон шалгаруулж, дүгнэлт гарган танилцуулахыг үнэлгээний хорооны нийт гишүүдэд даалгасугай.

ЗАХИРАЛ

Г.МӨНХЗУЛ

3130600020